

УВС АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР



5/31/2023

**ТУС ЦАГДААГИЙН ГАЗАРТ  
2023 ОНЫ 05 ДУГААР САРД  
БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ,  
ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ**

Улаангом хот

# Танилцуулга

## Нэг. ХҮЛЭЭН АВЧ ШАЛГАСАН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ


1.1 Тус Цагдаагийн газарт 2023 оны 05 дугаар сард иргэн, аж ахуйн нэгжээс 1269 дуудлага мэдээлэл хүлээн авч өмнөх сарын үлдэгдэл 41 нийт 1310 гомдол, мэдээлэл шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс -317 нэгжээр буюу -19.6 хувиар буурсан.

Гэмт хэргийн шинжтэй 315, зөрчлийн шинжтэй 995 гомдол мэдээллийг тус тус хуулийн хугацаанд шалгасан байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт



Гэмт хэргийн шинжтэй 38, зөрчлийн шинжтэй 38 нийт 78 гомдол, мэдээлэл буюу нийт шалгасан гомдол, мэдээллийн 5.8 хувь нь шийдвэрлэгдээгүй буюу хуулийн хугацаанд шалгаж байна.

### 1.2 Хүлээн авсан гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацааг харуулбал:




## Хоёр. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

### 2.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг:

Аймгийн хэмжээнд 176 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 54 нэгжээр буюу 44.3 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 72.5 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөнгөн гэмт хэрэг 153, хүнд гэмт хэрэг 23 бүртгэгдсэн. Хөнгөн хэргийн илрүүлэлт 75.0 хувьтай, хүнд хэргийн илрүүлэлт 57.9 хувьтай.


2.2 2023 оны 05 дугаар сард бүртгэгдсэн гэмт хэрэг: /нутаг дэвсгэрээр/:




Нийт гэмт хэргийн 108 буюу 61.3 хувь нь аймгийн төвд, 68 буюу 38.7 хувь нь сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

Аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 52 нэгжээр буюу 92.9 хувиар өсч, сумдын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 2 нэгжээр 3 хувиар өссөн байна.


2.3 Бүртгэгдсэн гэмт хэргийн газар нутгаар нь авч үзвэл:



## 2.4 Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/:



## 2.5 Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл:





## 2.6 Бүртгэгдсэн зарим гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/:

№	Гэмт хэргийн төрөл		Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт бууралт нэгжээр	Өсөлт бууралт хувиар
			2022.V	2023.V		
1	Бүх гэмт хэрэг		122	176	54	44.3
2	Хүний амьд явахын эрхийн эсрэг 10.1-10.6		2	2	Ижил түвшинд	
	Үүнээс	Санаатайгаар 10.1				
		Болгоомжгүйгээр хохироох 10.6	0	1	1	100
		Бусдыг амиа хорлоход хүргэх 10.4	2	1	-1	-50
13	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 11.1-11.7		43	46	3	7.0
4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг 12.1-12.5		4	9	5	2.3 дахин
	Үүнээс	Хүчиндэх 12.1	3	8	5	2.7 дахин
		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах 12.2				
		16 насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх 12.5.2	1	1	Ижил түвшинд	
	Хохирогчийг насны байдлаар	17 хүртэлх буюу хүүхэд хохирсон	3	6	3	2 дахин
		18 дээш насны	1	3	3	3 дахин
5	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг 13.1-13.13		0	1	1	100
6	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг 14.1-14.9					
7	Эрүүл мэндийн эсрэг 15.1-15.6		1	0	-1	-100
8	Хүүхдийн эсрэг 16.1-16.11					
9	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 17.1-17.12		58	94	36	62.1
	Хулгайлах гэмт хэрэг 17.1		14	16	2	14.3


	Дээрэм 17.2	2	1	-1	-50.0	
	Залилах 17.3	10	59	49	5.9 дахин	
	Эд хөрөнгө устгаж, гэмтээх 17.8	1	0	-1	-100	
	Хөрөнгө завших 17.4	1	3	2	3 дахин	
	Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, мал завших 17.5	3	2	-1	-33.3	
	Тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүй авах 17.7	1	2	1	100	
	Бусдын хөрөнгө устгаж гэмтээх , үрэгдүүлэх 17.11	2	1	-1	-50	
	Мал хулгайлах 17.12	24	10	-14	-58.3	
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 20.1-20.16					
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 23.1-23.7	8	14	6	75.0	
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг 24.1-24.9	3	4	1	33.3	
	Үүнээс	Хууль бусаар мод бэлтгэх 24.6	0	2	2	100
		Хууль бусаар ан агнуур 24.5	3	0	-3	-100
		Хууль бусаар ашигт малтмал олборлох 24.2				
		Химийн хорт, аюултай/б хууль бусаар эргэлтэнд оруулах 24.3				
		Ой хээрийн түймэр тавих 24.7	0	2	2	100
13	Тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 27.1-27.11	2	6	4	3 дахин	
14	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг /28.1-28.19/					

## 2.7 Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг:



## 2.8 Гэмт хэрэг үйлдсэн байдал:


Бүртгэгдсэн гэмт хэргийн 57 буюу 32.3 хувь нь согтуугаар, 19 буюу 10.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 61 буюу 34.6 хувь нь цахим орчинд, 17 буюу 9.6 хувь нь гудамж талбайд, 66 буюу 37.5 хувь нь гэр орон сууцанд тус тус үйлдэгдсэн байна.



## Гурав. ГЭМТ ХЭРГИЙН ИЛРҮҮЛЭЛТ

### 3.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь:

Гэмт хэргийн илрүүлэлт 72.5 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд илрүүлэлт 43.8 хувь, нийслэлд 42.9 хувьтай байна. Улсын дундажаас 28.7 хувиар их байна.



### 3.2 Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэгдээгүй 36 гэмт хэрэг:



## Дөрөв. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧ

### 4.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн:

Нийт 146 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49 нэгжээр буюу 50.5 хувиар өссөн.

Холбогдогчид нь эмэгтэй хүн үйлдсэн 18, хүүхэд үйлдсэн 7 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн.



### 4.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс:

		2022.V	2023.V
Гэмт хэрэг үйлдсэн бүх хүн		97	146
үүнээс:	Эмэгтэй	8	18
Нас	15 хүртэлх	2	3
	16-17	2	4
	18-24	14	16
	25-29	19	28
	30-34	19	52
	35-39	17	15
	40-44	11	12
	45-49	7	6
	50-дээш	6	10



## Тав. ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ, ХОХИРЛЫН ХЭМЖЭЭ

### 5.1 Хохирсон хүн, хүүлийн этгээд:



Гэмт хэргийн улмаас 174 хүн хохирч, 47 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 51 нэгжээр буюу 41.5 хувиар өссөн, гэмтсэн хүн 2 нэгжээр буюу 4.4 хувиар өссөн байна.

5.2 Учирсан хохирол: Иргэн, хуулийн этгээдэд учирсан 856.9 сая төгрөгийн хохирлын 705.5 сая төгрөг буюу 88.3 хувийг нөхөн төлүүлсэн.

### **Зургаа. ЗӨРЧИЛ**

#### **6.1 Нийт бүртгэгдсэн зөрчил:**

Тус цагдаагийн газарт нийт 11686 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2670 нэгжээр буюу 29.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### **6.2 Бүртгэгдсэн зөрчлийн ангилал:**

Зөрчил гаргасан 11329 иргэн, 0 хуулийн этгээдийг 370711.5 сая төгрөгөөр торгосон. Үүнээс бэлэн бус торгуулиар 10800 зөрчилд 221826.5 сая төгрөгний торгууль ногдуулсан.

124 хүнийг баривчлах, 204 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус ногдуулсан байна.

**0 Хуулийн этгээдэд торгууль ногдуулсан**

**124 Баривчилсан**

**204 Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, торгосон**


**11329 Хүнд торгууль ногдуулсан**

6.3 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа:

12 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19 буюу 61.3 хувиар буурчээ. Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 12 буюу 100 хувь нь эрэгтэй хүн байна.

#### **6.4 Сүүлийн 5 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо:**

эрүүлжүүлэгдсэн хүний тоо /сүүлийн 5 жилээр /



**НЭГТГЭСЭН:**

**МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ**

**М.ОДХҮҮ**